



**САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН**

Чандмань- Баянхонгор ХК-ийн 2019 оны санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:**БНА-2020/2/СТА-ОНӨААН

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Баянхонгор сум

2020 он

Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 70442584 Цахим хаяг: [munkhbatb@audit.gov.mn](mailto:munkhbatb@audit.gov.mn)

Аудитын менежер: А.Цээням

Утас: 70442424 Цахим хаяг: [tseenyama@audit.gov.mn](mailto:tseenyama@audit.gov.mn)

Аудитор: Д.Энхтуяа

Утас: 99449299 Цахим хаяг: [tomoo\\_etuya@yahoo.com](mailto:tomoo_etuya@yahoo.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**

1. Аудитын гэрчилгээ .....	3
2.Аудитын тайлан .....	5
2.1. Оршил .....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	5
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, аргазүй, шалгуур үзүүлэлт .....	5
2.4. Байгууллагын зорилго,үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	7
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	7
2.9 . Үйл ажиллагааны орлого, зардлын гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	9
2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горимсорил, түүний үр дүн.....	9
2.10.1 Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл.....	9
2.10.2.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал..	10
2.11. Дараагийн аудитаар авч үзэхбуюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	10
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	10
2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	10
2.14. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	11
3. Менежментийн захидал.....	11
4. Аудитлагдсан санхүүгийн тайлангууд.....	13
4.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	13
4.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	14
4.3. Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	14
4.4. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	15
5. Санхүүгийн тайлангийн тодруулгуудыг хавсралтаар хавсаргав.....	11 хуудас

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт

Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,  
Баянхонгор сум, Номгон баг  
Утас, факс 7044 2584  
E-mail: bayankhongor@audit.gov.mn

Ауд. 02.15 № 1/381

тантай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Аудитын гэрчилгээ

“БАЯНХОНГОР ЧАНДМАНЬ”  
ХК-ИЙН ЗАХИРАЛ  
Э.ЭНХБАТ ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-т заасны дагуу Баянхонгор Чандмань ХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Баянхонгор Чандмань ХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор Чандмань ХК ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт,

• 005020322

программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**Үүрэг хариуцлага**

Баянхонгор Чандмань ХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

## **1 Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Чандмань-Баянхонгор ХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн, дүгнэлтийг захирал Э.Энхбат-д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Чандмань-Баянхонгор ХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Чандмань-Баянхонгор ХК-ийн 2019 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон НББОУС, түүнд нийцүүлж гаргасан Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Чандмань-Баянхонгор ХК-ийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020.02.25-наас 2020.03.15-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020.03.15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Чандмань-Баянхонгор ХК-ийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, "Глобал капитал Аудит" ХХК-ийн аудитор Д.Энхтуяа, Б.Баасабат нар хариуцаж хэрэгжүүлэв.

Чандмань-Баянхонгор ХК-ийн 2019 оны санхүүгийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2020.03.12-ны өдрийн 37 тоот дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, аргазүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС, НББОУС, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

#### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Чандмань-Баянхонгор ХК-ийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго: Чандмань-Баянхонгор ХК нь “Чадварлаг хүний нөөц, байгальд ээлтэй дэвшилтэд технолгиор ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэж, хөгжилд тэмүүлсэн манлайлагч байгууллага болно” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

- Ус хангамж, ариутгах татуурга, дулаан хангамж
- Сантехникийн засвар үйлчилгээ
- Барилга угсралт
- Тоолуур суурилуулалт
- Засвар үйлчилгээ

Чандмань-Баянхонгор ХК –ийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Чандмань-Баянхонгор ХК нь удирдлага Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Компанийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

#### **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Чандмань-Баянхонгор ХК –ийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Чандмань-Баянхонгор ХК-ийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Чандмань-Баянхонгор ХК нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Ритус ХХК-ийн "Ноён" санхүүгийн программ ангамж ашигладаг байна.

Чандмань-Баянхонгор ХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Чандмань-Баянхонгор ХК-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд 42 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын 2 хувиар сонгов.

Материаллаг байдлын суурийг үр дүнгийн тайлангийн нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгох нь нь зохимжтой гэж үзэв.

Чандмань-Баянхонгор ХК-ийн 2019 оны 3 дугаар улирлын орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал төлөвлөлтийн шатанд 725827,3 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 14516,5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн шатанд 2019 оны нийт зардал 1695041,9 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 33900,8 мянган төгрөгөөр тооцсон нь төлөвлөлтийн шатанд сонгосон суурь үзүүлэлт нэмэгдсэнтэй холбоотой материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг Б401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## **2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд**

Чандмань-Баянхонгор ХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 535,002.0 мянган төгрөгөөр буюу 18,9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

## Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	18,270.60	140,429.20	122,158.60
Авлага	45,600.50	60,335.30	14,734.80
Бараа материал	85,111.80	115,296.40	30,184.60
Үндсэн хөрөнгө	3,407,666.30	3,905,359.10	497,692.80
Хуримтлагдсан элэгдэл	(738,368.80)	(868,137.00)	(129,768.20)
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>2,818,276.8</b>	<b>3,353,283.00</b>	<b>535,006.2</b>
Богино хугацаат өр төлбөр	99,404.90	309,731.90	210,327.00
Үүнээс: Урьдчилж орсон орлого		170,180.0	170,180.0
Урт хугацаат өр төлбөр	185,395.00	161,910.50	(23,484.50)
<b>Нийт өр төлбөр</b>	<b>284,799.9</b>	<b>471,642.4</b>	
Орон нутгийн өмч	313,835.00	313,835.00	-
Хувийн өмч	78,458.80	78,458.80	-
<b>Өмчийн дүн</b>	<b>392,293.8</b>	<b>392,293.8</b>	
Дахин үнэлгээний нэмэгдэл	595,487.00	595,487.00	-
Эздийн өмчийн бусад хэсэг	1,201,106.60	1,411,286.30	210,179.70
Хуримтлагдсан үр дүн	344,589.4	482,573.50	137,984.1
<b>Цэвэр хөрөнгө , өмчийн дүн</b>	<b>2,533,476.9</b>	<b>2,881,640.7</b>	<b>348,163.8</b>
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>2,818,276.8</b>	<b>3,353,283.00</b>	<b>535,006.2</b>

Мөнгөн хөрөнгө тайлан онд 122,158.6 мянган төгрөгөөр өссөн нь Баянхонгор сумын ЗДТГ-аас 5 дугаар багийн дулааны шугмын ажлыг хэрэгжүүлэээр 125,000.0 мянган төгрөг урьдчилж орсонтой холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 30,184.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд өөрийн хөрөнгөөр 548,383.2 мянган төгрөгийн худалдан авалт хийж, орлого авч 518,198.6 мянган төгрөгийн зарцуулснаас шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд өмнөх онуудад худалдаж авсан ашиглалтгүй нөөцөлсөн бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 497,692.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд өөрийн хөрөнгөөр 119,466.2 мянган төгрөг, бусад эх үүсвэрээр 501,176.0 мянган төгрөг, Баянхонгор аймгийн ИТХ-ын 2019 оны 01 дүгээр сарын 31-ний 17 тоот тогтоолоор шилжүүлэн авсан 210,179.7 мянган төгрөг бүгд 838,822.0 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, 333,129.1 мянган төгрөгийн Спорт заалны барилгыг дуусаагүй барилга байгууламжаас үндсэн хөрөнгөнд шилжүүлснээс шалтгаалжээ.

Тайлант онд урьд оноос богино хугацаат өглөг 210,327.0 мянган төгрөгөөр өссөн нь татварын өр, урьдчилж төлсөн орлого өссөнтэй холбоотой байна. Үүнд : Баянговь сумын цэвэр усны шугмын ажилд 35,000.0 мянган төгрөг, 5 дугаар багийн дулааны шугмын ажилд 125,000.0 мянган төгрөг, Өлзийт сумын ЗДТГ-ын бохир соруулах ажилд 180.0 мянган төгрөг, 6 дугаар Цэцэрлэгийн бохирын шугам шинэчлэх ажилд 10,000.0 мянган төгрөгний ажил хийгдэхээр урьдчилж орсон орлого 170,180.0 мянган төгрөгийг богино хугацаат өр төлбөрөөр бүртгэсэн

байна

Цэвэр хөрөнгийн дүн 348,160,0 мянган төгрөгөөр өссөн нь нь тайлант үеийн үр дүн, эзэмшигчдийн бусад хэсэг өссөнтэй холбоотой байна Тайлант онд төрийн болон хувийн өмч, дахин үнэлгээний нэмэгдэл дансанд өөрчлөлт ороогүй байна .

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга гараагүй.

## **2.9 . Үйл ажиллагааны орлого, зардлын гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Тус компанийн 2019 оны бизнес төлөвлөгөөг ТУЗ-ын 2019 оны 05 дугаар сарын 01 – ний өдрийн 01 тоот тогтоолоор баталсан байна. Энэ тогтоолоор 2019 онд 1,586,669,6 мянган төгрөгийн орлоготой, 1,513,719.4 мянган төгрөгийн зардал гаргаж, 65,655.1 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажиллахаар төлөвлөсөн байна. Гүйцэтгэлээр орлого 1,832,887,0 мянган төгрөг, нийт зардал 1,679,3921 мянган төгрөг 137,845.5 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж , төлөвлөгөөг давуулан биелүүлсэн байна.

Батлагдсан төлөвлөгөө , гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

## **2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горимсорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 8 чиглэлээр аудитын 36 горим сорил, нэмж 2 сорил гүйцэтгэж, үнэлэхэд 7 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 31 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэв.

Аудитаар нийт 239,985.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэнд 5,897,0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 233,088.1 мянган төгрөгийг дахин давтахгүйн зөвлөмж өгөв

Аудитаар дараах 5,897.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа зөрчилд төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэлээ. Үүнд.

### **Илрүүлэлт:**

Харилцах данс болон бэлэн мөнгөний гүйлгээг шалгахад баримт бүрдэл дутуу гүйлгээ хийсэн, хувь хүн, иргэдээс худалдан авсан 58970.4 мянган төгрөгийн бараа материалын үнээс ХХОАТ-ын 10 хувь суутгаагүй байна

Энэ нь ХХОАТ-ын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1-т “Энэ хуулийн 25.4-т “Суутган төлөгч нь хувь хүнд орлого олгох бүрдээ түүний албан татвар төлөгчийн дугаар болон хувь хүн тус бүрээр олгосон орлого, түүнд ногдуулан суутгасан албан татварын хэмжээний мэдээллийг цахимаар, эсхүл хувь хүний орлого, татварын бүртгэлийн дэвтэрт тэмдэглэж, харьяа татварын албанд улирал тутам өссөн дүнгээр гаргаж илгээнэ” гэсэн заалтыг зөрчсөн гэсэн заалт зөрчсөн байна.

**Эрсдэл :** Татварын акт тавигдаж , торгууль алданги хүлээх

**Шийдвэрлэсэн нь:** Төлбөрийн акт тогтоов

Аудитаар олон жилийн насжилт өндөр авлага, татварын өр, ашиглалтгүй хөрөнгө зэрэг зөрчилд зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

## **2.10.1 Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл**

Байхгүй

**2.10.2 Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал.**

№	Шийдэл	Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал		
		Тоо	Дүн	Тайлбар
1. Төлбөрийн акт тогтоов		1	5,987.0	
	Дүн	1	5,987.0	

(Мянган төгрөгөөр)

**2.10.2.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал**

Байхгүй

**2.11. Дараагийн аудитаар авч үзэхбуюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Байхгүй

**2.12. Шилэн дансны мэдээлэл**

Чандмань-Баянхонгор ХК-ийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

**2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

2019 оны жилийн эцсийн байдлаар Азийн хөгжлийн банкны зээлийг санхүүгийн тайланд тусгах шаардлагагүй гэж үзэж, 2019 оны 09 сарын 24-ний 163 тоот албан тоотоор хариу өгсөн байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

**2.14. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Чандмань-Баянхонгор ХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд аудит хийхдээ АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Чандмань-Баянхонгор ХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тусгасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.,

### **3. Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийн хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд

#### **1.Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл**

**1.1. Илрүүлэлт:** 2010 оноос хойш шийдвэрлэгдээгүй Хот тохижилттой холбоотой 22415,9 мянган төгрөг, аймгийн ЗДТГ-ын бор балгасын усжуулалтын системтэй холбоотой 11452,7 мянган төгрөгийн авлага байна . Энэ нь НББ-ын тухай хуулийн 20.2.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71.8 дахь заалтуудыг зөрчсөн байна.

**1.2. Эрсдэл:** Үндэслэлгүй авлага нэмэгдэж, санхүүгийн үзүүлэлтэд нөлөөлөх

#### **1.3. Өгсөн зөвлөмж:**

Дансанд бүртгэлтэй Хот тохижилтоос авах 22415,9 мянга, аймгийн ЗДТГ-аас авах 11452,7 мянган төгрөгийн авлагыг аймгийн ИТХ-д асуудал оруулж, шийдвэрлүүлэх.

#### **1.4.Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана

**2.1. Илрүүлэлт:** Кассын тайлангийн үлдэгдлээс бэлэн мөнгөний үлдэгдлийг гаргаж хадгалаагүй ба НББ-ын бичиг баримт болон тус компанийн Мөнгөн кассын болон бэлэн мөнгөний журамд мөнгөний үлдэгдлийг тодорхой заагаагүй мөнгөн кассын журам зөрчсөн байна:

**2.2. Эрсдэл:** Бэлэн мөнгө дутагдах , шамшигдах

**2.3. Өгсөн зөвлөмж:** Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.2 дахь заалтын дагуу мөрдөж байгаа НБББББ-д мөнгөн кассын ажиллагааны талаар өөрчлөлт оруулах, мөнгөн кассын журмыг шинэчлэх батлуулж мөрдөж ажиллах

#### **2.4.Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана

**3.1. Илрүүлэлт:** 2019 оны жилийн эцсийн тооллогын бүртгэлээр эвдэрсэн болон актлах шаардлагатай 45 нэр төрлийн 15698,3 / үлдэх өртөг/ мянган төгрөгийн хөрөнгө байна.

**3.2. Эрсдэл:** Ашиглалтгүй хөрөнгө нэмэгдэх

**3.3. Өгсөн зөвлөмж:** Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31.1.3-т заасан заалтын дагуу холбогдох газруудад асуудал тавьж бүртгэлд тусгагдсан эвдэрсэн болон актлах шаардлагатай хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэх.

**3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана

**4.1. Илрүүлэлт:** Бараа материалын худалдан авалтыг гэрээтэй тулган, НӨАТ-ын падаантай эсэхийг шалгахад хувь хүмүүсээс худалдан авсан барааны үнийг Е баримтгүй гүйлгээ хийсэн 51 удаагийн 58970,4 мянган төгрөгийн гүйлгээ гарсан байна.

**4.2. Эрсдэл:** Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль зөрчих, анхан шатны бүрдэлгүй гүйлгээ хийх

**4.3. Өгсөн зөвлөмж:** Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.4, 13.5 дахь заалт, Татварын хуулийн 28,5 дахь заалтыг мөрдөж Е баримтгүй ажил гүйлгээ хийдэг явдлыг таслан зогсоож ажиллах

**4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана

**5.1. Илрүүлэлт:** ХХОАТ-ын өглөг 5017,4 мянган төгрөгөөр Татварын хэлтсийн тайлангаас зөрүүтэй байна.

**5.2. Эрсдэл:** ХХОАТ-ын хууль зөрчих, үндэслэлгүй өр авлага нэмэгдэх

**5.3. Өгсөн зөвлөмж:** Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5. "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах; өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх". гэсэн заалтын дагуу дахин тооцоо нийлж баталгаажуулж, Татварын хуулийн дагуу тайлагнах, төлөх

**5.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана

**6.1. Илрүүлэлт:** 2019 оны санхүүгийн тайланд 309731,8 мянган төгрөгийн өр байгаагийн 40 хувийг татварын өр эзэлж байна. Энэ нь ААНБОАТ-ын өр 9186,9 мянган төгрөг, НӨАТ-ын өр 95759,9 мянган төгрөг, ХХОАТ-ын өглөг 10351,9 мянган төгрөг, үл хөдлөх хөрөнгийн татвар 3150,5 мянган төгрөг, бусад татварын өглөг 1084,2 мянган төгрөг байна Нийт татварын өглөг 119533,4 мянган төгрөг, урьдчилж төлсөн орлого 185739,4 мянган төгрөг, бусад өглөг 4459,0 мянган төгрөг байна.

**6.2. Эрсдэл:** Өр их хэмжээгээр нэмэгдэх, санхүүгийн үзүүлэлтэд нөлөөлөх

**6.3. Өгсөн зөвлөмж:** Татварын ерөнхий хуулийн 28.1 дэх заалтын дагуу татварын 119533,4 мянган төгрөгийн өр болон бусад өрийг бүрэн барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллах.

**6.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана

#### 4.АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГУУД

##### 4.1. АУДИТ ЛАГДСАН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2019 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон жил

СТ-1

(Төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	Тодруулга	Аудитлагдсан үлдэгдэл	
		2018-12-31	2019-12-31
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	5.1	18,270,638.92	140,429,260.56
Дансны авлага	5.2	11,462,921.68	25,131,186.43
Бусад авлага	5.3	34,137,641.42	35,204,107.98
Бараа материал	5.4	84,244,412.41	115,296,403.99
Бусад эргэлтийн хөрөнгө	5.5	867,371.69	
<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>		<b>148,982,986.12</b>	<b>316,060,958.96</b>
Үндсэн хөрөнгө	5.6	2,659,773,784.32	3,013,444,743.48
Биет бус хөрөнгө	5.7	9,520,029.77	23,777,383.66
<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>		<b>2,669,293,814.09</b>	<b>3,037,222,127.14</b>
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>2,818,276,800.21</b>	<b>3,353,283,086.10</b>
Дансны өглөг	5.8	42,754,548.17	185,739,444.68
Татварын өр	5.8	43,159,939.62	123,992,429.79
НДШ - ийн өглөг	5.8	13,490,344.63	
<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>		<b>99,404,832.42</b>	<b>309,731,874.47</b>
Урт хугацаат зээл	5.9	185,395,028.00	161,910,509.13
<b>Урт хугацаат өрийн дүн</b>		<b>185,395,028.00</b>	<b>161,910,509.13</b>
<b>ӨР ТӨЛБӨРИЙН НИЙТ ДҮН</b>		<b>284,799,860.42</b>	<b>471,642,383.60</b>
Өмч: төрийн	5.10	313,835,027.38	313,835,027.38
хувийн	5.10	78,458,800.00	78,458,800.00
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	5.10	595,487,073.82	595,487,073.82
Эздийн өмчийн бусад хэсэг	5.10	1,201,106,611.10	1,411,286,311.10
Хуримтлагдсан ашиг	5.10	344,589,427.49	482,573,490.20
<b>ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>		<b>2,533,476,939.79</b>	<b>2,881,640,702.50</b>
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>		<b>2,818,276,800.21</b>	<b>3,353,283,086.10</b>

#### 4.2. АУДИТЛАГДСАН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

2019 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон жил

СТ-2

(Төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	Тод	Аудитлагдсан	
		2018-12-31	2019-12-31
Цэвэр борлуулалт	5.11	1,420,999,774.96	1,676,260,165.38
Борлуулсан барааны өртөг	5.13	862,555,343.80	1,399,764,280.26
<b>Нийт ашиг</b>		<b>558,444,431.16</b>	<b>276,495,885.12</b>
